

«ШИНЭ ТОЛЬ ХЭМЭЭХ БИЧИГ» СОНИНЫ МЭДЭЭНИЙ ОНЦЛОГ

2017

Ч. Чойсамба\*

\* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор

**Түлхүүр үг:** «Шинэ толь хэмээх бичиг», ууган хэвлэл, мэдээ, гарчиг, боолт, уруугаа харсан пирамид, газар зүйн хүрээ

**М**онголын ууган тогтмол хэвлэл «Шинэ толь хэмээх бичиг» сонин 1913 оны 3 дугаар сарын 6-нд анхны дугаараа гаргаснаас хойш даруй 100 жил өнгөрөөд байна. Эхний дөрвөн дугаар нь 23\*15 см-ийн хэмжээний 30-40 хуудастай номын хэлбэрээр, дараах 16 дугаар нь 34\*26 см-ийн хэмжээний 6-10 нүүртэй сонины хэлбэрээр хэвлэгдэж, 1914 оны 8 дугаар сарын 21 хүртэл бүгд 20 дугаар гарчээ.

«Сонин Оросоос Монголд суугаа төлөөний сайдын ивээлд гарч байсан нь хоёр талын эрх ашигт нийцэж байв. Монголын дэвшилт сэхээтнүүд Оросын хэвлэлийн баазыг ашиглан тогтмол хэвлэл гаргахыг зорьж байсан бол оросууд уг хэвлэлд өөрийн бодлогыг шургуулах эрмэлзэлтэй байв. Гэвч уг хэвлэлийн жинхэнэ эрхлэн гаргагчид нь Монголын дэвшилт үзэлт сэхээтнүүд байсан учир анхныхаа дугаараас эхлэн үнэн хэрэг дээрээ хэнээс ч үл хамаарах бие даасан бодлоготой тогтмол хэвлэл болон гарчээ»<sup>1</sup>.

Түүхэн үнэт баримт бичиг болох эрт сонины зарим дугаар олдохгүй байгаа гийн улмаас Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй 10 дугаарт нийтлэгдсэн мэдээг судалгааны объект болгов.

«Шинэ толь хэмээх бичиг»-т мэдээний эзлэх жин бага байсан бөгөөд, том хэмжээний өгүүлэл, нийтлэл, орчуулгын материал зонхилж байжээ. Нэг том материал хэд хэдэн дугаар дамжин нийтлэгдэж байв. Тухайлбал: Францын зохиолч Грамштерны бичсэн XIII зууны үеийн Монголын байлдан дагууллын тухай «Хөх Монголын хөх туг» романыг дугаар болгондоо, Финляндын монголч эрдэмтэн Рамстедтийн бичсэн «Уйгур улсын хураангуй түүх»-ийг сүүлийн дугаарууддаа (Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй дугааруудаас 15-18 дахь нь байхгүй тул чухам аль дугаараас эхэлснийг тогтоох боломжгүй юм), Оросын түүхийг 10-14 дэх дугаартаа (мөн шалтгааны улмаас хэд дэх дугаар хүртэл үргэлжилснийг тогтоох боломжгүй) нийтэлж байжээ.

Энд нэг зүйлийг зориуд тэмдэглэхэд зуун өмнө хэвлэгдэж байсан сонины мэдээг орчин үеийн сэтгүүл зүйн шалгуураар шүүж, үнэлэлт дүгнэлт өгөхийг зориогүй болно. «Шинэ толь хэмээх бичиг»-ийг эрхлэн гаргагчид нэн

ялангуяа гадаадын үйл явдлыг тусгахдаа юуны түрүүнд монгол уншигчдын мэдлэгийн цар хүрээг харгалзан үзэж байсныг үгүйсгэхгүй.

«Шинэ толь хэмээх бичиг» сонины мэдээ дийлэнхдээ гарчиггүй, гол төлөв «Сонсгол», «Сонсвоос», «Элдвийн олон чимээ», «Цахилгаан чимээ» (сүүлд «Цахилгаан мэдээ») боолтуудын дор нийтлэгдэж байжээ. Эсвэл уг мэдээг авсан өдрөөр гарчигладаг байв: «Зургаан сарын хорин нэгний цахилгаан мэдээ», «Долоон сарын шинийн нэгний цахилгаан мэдээ» г. м. Мэдээг анхандаа «чимээ» гэж нэрлэж байсан нь эндээс харагдана.

**Т**ус сонины мэдээний газар зүйн хүрээ нэн хязгаарлагдмал ажээ. Монгол, Орос, Хятад гурван улсын тухай мэдээ нийт мэдээний 82 хувийг эзэлж байна. «Шинэ толь»-ийн 8 дугаарт нийтлэгдсэн «Сонсвоос» булангийн 4 мэдээ дөрвүүлээ Оросын тухай байх жишээтэй. Эдгээр нь загасны түрс ашиглах, Петербург дахь олон улсын эмч нарын хурал, булганы тухай 2 мэдээ байна. Ер нь ихэнх мэдээ ахуйн чанартай, монгол уншигчдад төдийлөн сонирхолгүй ажээ.

Мэдээнүүдэд ажиглагдаж буй түгээмэл шинж бол тойм төдий, тодорхой (тоо, нэр ус г. м.) баримтыг харьцангуй цөөн ашигласан зэрэг юм. Тухайлбал:

*Дунд Америк тивд байх бага улс Мегсигэ (Мексик – зох.), хойт Америк тивд байх их Ме улс (АНУ – зох.) хоёр алалдаж буй. Учир нь Мегсигэ улсын засаг нь муу, хэдийгээр бүгд найрамдсан боловч даргын тушаал булаалдан хямралдаж, өөр дотроо хэдэн нам хоршоо нийлэн цэрэглэсээр гадаад дотоодыг хамгаалж үл чадан, улс эвдрэхүйд хүргэжүхүй. Энэ улс*

*лугаа хойт этгээдэд зах нийлсэн Ме улс хэмээх Хойт Америкийн их улс өөсөв эрж, усан замын цэрэг явуулан, Мегсигэ улсын харьяат далайн нэгэн боомт хотыг авчухуй. Самуурсан мегсигэ нар Ме улсад эзлэгдэх цаг тулж хэмээн сая мэдмэгц хоорондоо алалдан зууралдсан намууд цөм эвлэрч нэгэн саналаар гадаадын дайсныг эсэргүүцэн байлдан орохуйд Ме улс их л бачимдан усан замын цэргийн дээр нэмж хуурай замын цэрэг гаргахаар тогтжухуй. Мегсигэ улсын газар нь хойт, өмнө хоёр Америкийн дунд, бас хоёр их далайн завсар болох бөгөөд бас газрын өмхий тос гардаг ашиг ихтэй улс тул Англи, Жибан (Япон – зох.) хоёр улс мөнхүү Мегсигэ улсыг өмгөөлөх дуртай, хоёулаа Ме улс лугаа тийм л сайнгүй хэмээжүхүй. Их Ме улс сүр үзүүлсүгэй хэмээн дөчин түмэн цэрэг гаргахаар завдаж буй. Мегсигэ улсын цэрэг тавхан түм хэмээвч ард албат нар их бага, эр эм хамаагүй цөм их л цухалдан зэвсэг барьцгааж, газар орноо хамгаалсугай хэмээмүй.*

«Шинэ толь хэмээх бичиг» сонины нийт мэдээнд (61) дурдагдсан гадаад улсуудын нэрсийг ажиглахад сонирхолтой. Дэлхийн нэгдүгээр дайны тухай мэдээнүүдэд гадаад улсуудын нэрс бусад мэдээнээс харьцангуй их тохиолдлоо. Эдгээр 8 мэдээнд нийт 13 улсын нэр тааралдаж буй бол бусад 53 мэдээнд ердөө 11 улсын нэр (Монголыг оруулаад) гарч байна. Энэхүү 53 мэдээнд хэрэв Монгол гэсэн нэр 37, Орос 49, Хятад 20 удаа дурдагдсан бол давтамжаараа дараагийн гурван байрыг Америк (7 удаа), Мексик (7), Жибан (6) эзэлж буй юм. Зарим улсын нэрийн бичлэг одоогийн-

хоос харьцангуй өөр байсан нь монгол бичгийн эгшиг зохицох ёстой холбоотой аж: Германи, Австари, Ангали, Фаранцус, Голанди г. м.

Гадаад мэдээг өргөн тусгахын зэрэгцээ «Шинэ толь хэмээх бичиг» сонин дотоодын амьдралд багагүй анхаарал хандуулж байв. Улс орны бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын асуудал нь манай ууган хэвлэлийн нийтлэлийн цөм болж байжээ. Жишээ нь:

Өмнө зүгээс залуу идэр хятадууд маш олон цувран ирсээр бүгд Монгол албаны хүмүн нар татвар гаалуйг арбин авахыг хичээхээс бус, маргааш нөгөөдрийг ер бодох санахгүй амуй.

Энэ мэт хятадууд ирсээр хэд хэдэн түм бумд хүрвээс захирах, хөөн гаргах, хүргэн тушаах, илбин дуусгах алин болохыг одооноос сэрэмжлэн хяналтай мэт байна.

«Шинэ толь хэмээх бичиг» одоогийн хэвлэлүүдийн адил туйлширдаггүй байсан нь сайшаалтай. Хэдийгээр дээрх мэдээнд хятадуудыг шүүмжилж байсан ч «Шинэ толь хэмээх бичиг» хазайж гуйвдаггүй, үнэн бодит мэдээллийг хэлбэрэлтгүй баримтладаг нь дараах жишээнээс харагдлаа:

Хүрээний зах дээрх байдлыг ажиглаваас, цагдаа нар шударгаар явахгүй, хулгай худал гарваас хулгайчийг олохгүй, харин холгогдсон хүмүнийг сураар хүлж авч ирэх нь үзэгдмүй. Саяхан нэгэн хятад модоч дарханы хэдэн сүхийг монгол банди нар холгосныг сүхний эзэн бариад

сүхээ авах гэтал нэгэн цагдаа харайн ирээд, харин хятадыг хүлж, хулгай чийг тавив. Энэ мэт бүдүүлэг хэрэг үргэлж сонсдмуй.

«Шинэ толь хэмээх бичиг»-ийн нийтлэл дээр нь тулгуурлан чөлөөт хэвлэл гэж үзэх үндэслэлтэй юм. Улс орны төр засгийн бурангуй тогтолцоо Монголын дээд ба доод хурал дахь захрал, орон нутгийн засаг захиргааны аппаратын хүнд суртал гээд «Шинэ толь хэмээх бичиг»-ийн хувьд шүүмжилж болдоггүй оргил гэж байсангүй. «Шинэ толь хэмээх бичиг» зүгээр нэг шүүмжлэгч төдийгүй, бас үүний зэрэгцээ ард түм-

«  
*Улс орны төр засгийн бурангуй тогтолцоо, Монголын дээд ба доод хурал дахь захрал, орон нутгийн засаг захиргааны аппаратын хүнд суртал гээд «Шинэ толь хэмээх бичиг»-ийн хувьд шүүмжилж болдоггүй оргил гэж байсангүй.*

»

ний эрх ашгийг хэлбэрэлтгүй хамгаалагч байсан юм<sup>2</sup>.

Энэ тухай хэвлэлийн түүх судлаач шинжлэх ухааны доктор Г.Дэлэг: «Дарлагдсан олны эрх ашгийг тууштай хамгаалж, ноёлогч ангийн бузар бурангуй явдлыг илчлэн, хурц шүүмжилж байснаараа "Шинэ толь хэмээх бичиг" ард олны эрх ашгийг хамгаалсан хэвлэл байлаа. Тэгээд ч дарлагдан мөлжигдсэн үй олны саналыг илэрхийлж, тэдний тэмцлийн дуу хоолой болж байв»<sup>3</sup>.

Баруун Ховдын хязгаар Монголын сайд нэн олон нь гайхамшигтай хэмээмүй. Санаваас, Ховдын хэдхэн аймгуудыг захирахуйд Хүрээнээс хязгаарт захирах сайд нэгийг тавиад, бусад чухал тушаалуудыг нутгийн шударга ноёд түшмэдэд даалгаж, аливаа хэргийг шийдүүлвээс зохих

мэт. Одоо хэр Монгол засгийн газраас тавьсан сайдын тоо тав зургаа хүрчүү хэмээмүй. Бас эдгээр сайдын доор бүхий түшмэд ба бараа бологчид цөөнгүй. Бүгд улсын сангаас хэрэглэл авмүй хэмээхээс гадна тэр газраа шүүх хэрэглэл, ард албатыг дэмий ихэмсэглэн сүрдүүлмүй. Төдий олон эрхтэн ямбатныг тэжээсний ач тус огт үгүй, тэдгээрийн хийх хэрэг ч үгүй мэт. Нэгэн сэргэлэн хүмүн хүч хүрэх албанд өдий олон сайдуудыг суулгасан нь улсад чирэгдэл, олон түмэнд зовлон болохоос өөр юмгүй аж.

«Шинэ толь хэмээх бичиг»-ийн мэдээг бичигдсэн арга барилын хувьд задлан үзвэл, уруугаа харсан пирамид бүтэц тохиолдоогүй бөгөөд, гол төлөв мэдээний эхэнд үндсэн санаа, агуулгыг тоймлон өгөөд, түүнийгээ цааш дэлгэрүүлж байжээ. Түүнчлэн мэдээг хронологи маягаар буку үйл явдалд болж өнгөрсөн дарааллаар бичих нь цөөнгүй.

Тус сонины 61 мэдээ нийт 3.357 үгээс бүрдэж байна. Энэ нь 1 мэдээ дунджаар 55 үгтэй (доод хэмжээ – 15, дээд хэмжээ – 187) гэсэн үг. Энэхүү 3.357 үг 172 өгүүлбэрт багтаж байгааг үзвэл нэг өгүүлбэр 19,5 үгтэй (доод хэлбэлзэл – 5, дээд хэлбэлзэл – 67 үг) байна. Энэ үзүүлэлтээрээ 1910-аад оны сонины өгүүлбэр нь 1920-1940-өөд оныхоос цөөн үгтэй байжээ. Харин 20 ба түүнээс дээш үгтэй өгүүлбэрийн тоо 41,9 хувь байсан нь 1920-иод оны хэвлэлийнхээс бага ч, 1940-өөд оныхоос ялимгүй илүү юм.

Нэг мэдээ 1-12, дунджаар 2,8 өгүүлбэрээс бүрдэж байна. 1-4 өгүүлбэртэй мэдээ 80,4; 5-8 өгүүлбэртэй мэдээ 14,5; 9-12 өгүүлбэртэй мэдээ 5,1 хувь

тохиолдлоо (хавсралт хүснэгтээс дэлгэрэнгүй үзнэ үү). 1910-аад оны хэвлэлд хамгийн түгээмэл нь нэг өгүүлбэр бүхий мэдээ байжээ (37,5%).

«Шинэ толь хэмээх бичиг» сонин Монголын тогтмол хэвлэлийн эхийг тавьснаараа, мэдээ хэмээх бичлэгийн зүйлийг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулснаараа ач холбогдолтой юм.

### Ишлэл

- <sup>1</sup> Норовсүрэн Л. 2011. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Хоёр дахь хэвлэл. (Тэргүүн боть). УБ., 114 дэх тал.
- <sup>2</sup> Чойсамба Ч. 2000. Монгол сонины мэдээ. УБ., 63 дахь тал.
- <sup>3</sup> Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тойм. УБ., 102 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2009. ХХ зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. (Тэргүүн дэвтэр). УБ.
2. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тойм. УБ.
3. Цэвээн Ж. 1998. Түүвэр зохиолууд. (Нэгдүгээр дэвтэр). УБ.
4. Цэвээн Ж. 2010. Нийтлэл, тэмдэглэл, захидал. УБ.
5. Норовсүрэн Л. 2011. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Хоёр дахь хэвлэл. (Тэргүүн боть). УБ.
6. Норовсүрэн Л. 2005. Монголын нийтлэл. (Дэд дэвтэр). УБ.
7. Чойсамба Ч. 2000. Монгол сонины мэдээ. УБ.

### Резюме

В статье автор затрагивает вопросы мастерства подачи международных и локальных новостей «Газеты, именуемой Новое зеркало» — основоположницы монгольской журналистики. Семантический анализ новостей выявил их специфику и общие черты, позволившие автору прийти к выводу, что «Газета, именуемая Новое зеркало» являлась независимой

прессой, которая своей публикацией последовательно защищала интересы простого народа и остро критиковала государственное устройство Монголии, бюрократический чиновничий аппарат,

вседозволенность и необузданность кучки аристократов, диктовавших свои условия на заседаниях верхней и нижней Палаты страны при вынесении важных решений и т. п.